КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Эрдэнэс Газ” ХХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу байгалийн хий нийлүүлэх хоолойн төслийн хүрээнд Монгол Улсын төрийг төлөөлөн ажиллах, төслийн хэрэгжилтийг аж ахуйн нэгжийн түвшинд зохион байгуулах, байгалийн хийн дэд бүтэц болон хийн хангамжийн тогтолцоог хөгжүүлэх, мөн нэгдлийн тээвэр, логистикийн стратегийг хэрэгжүүлэх, логистикийн төвүүдийг байгуулах, авто зам, төмөр замын тээврийн менежментийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн өмчит компани юм.

АЛСЫН ХАРАА

Монгол Улсыг бүс нутгийн байгалийн хийн тээвэр, логистикийн стратегийн зангилаа болгон хөгжүүлж, байгалийн хийн дэд бүтэц, нийлүүлэлт, логистикийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн, тогтвортой үнэ цэнэ бүтээгч үндэсний компани байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх байгалийн хийн дамжуулах хоолойн төслийн хүрээнд төрийн төлөөллийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, төслийн хэрэгжилтийг аж ахуйн нэгжийн түвшинд мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, байгалийн хийн дэд бүтэц болон тээвэр, логистикийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн хөгжил, эрчим хүчний аюулгүй байдал, компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах.

ҮНЭТ ЗҮЙЛС

- **Үндэсний эрх ашиг** – Монгол Улсын стратегийн дэд бүтцийн төслүүдийг үндэсний эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлнэ;
- **Ил тод, хариуцлагатай засаглал** – компанийн үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлага, сайн засаглалын зарчмыг баримтална;
- **Мэргэжлийн ур чадвар** – мэргэжлийн хамтын ажиллагаа, мэдлэгийн солилцоо, багийн чадавхад тулгуурлан стратегийн дэд бүтцийн төслүүдийг өндөр мэргэжлийн түвшинд хэрэгжүүлнэ;
- **Хамтын ажиллагаа** – олон улсын болон дотоодын түншлэлд тулгуурлан харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ;
- **Тогтвортой хөгжил** – байгаль орчин, нийгмийн хариуцлага, эдийн засгийн үр ашгийг тэнцвэртэй хангана;
- **Үр ашиг ба үнэ цэнэ** – компанийн нөөцийг үр ашигтай ашиглаж, хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Эрдэнэс Монгол” нэгдлийн 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Борлуулалт логистикийн стратегийн хүрээнд экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн гинжин хэлхээг бүрдүүлэх

зорилгоор тээвэр, логистикийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, логистикийн төвүүдийг байгуулах, дэд бүтцийг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн байдаг. Энэ хүрээнд “Эрдэнэс Газ” ХХК нь дараах стратегийн үндсэн чиглэлүүдэд төвлөрч үйл ажиллагаа явуулна.

Нэг. *Байгалийн хийн дэд бүтэц*.

Хоёр. *Тээвэр, логистикийн дэд бүтэц.*

Гурав. *Түлшний нийлүүлэлт*.

ЧИГ ҮҮРЭГ

Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий нийлүүлэх “Сибирийн Хүч-2” дамжуулах хоолойн Монгол хэсгийн төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, барилга угсралтын үе шатанд шилжих бэлтгэл ажлыг хангах, цаашид байгалийн хийн дотоодын дэд бүтэц, хийн хангамжийн тогтолцоо болон тээвэр, логистикийн салбарын хөгжлийг дэмжих стратегийн үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичиг юм.

Компанийн үйл ажиллагаа нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын Хараа — 2050”, Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2024-2028), “Шинэ сэргэлтийн бодлого”, мөн “Эрдэнэс Монгол” нэгдлийн 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй нягт уялдан хэрэгжинэ.

СТРАТЕГИЙН ГУРВАН ЧИГЛЭЛ

Байгалийн хийн дэд бүтэц, тээвэр логистикийн дэд бүтэц, түлшний нийлүүлэлтийн хөгжлийг шинжилгээ судалгаа, мэргэжлийн төлөвлөлт, талуудын үр дүнтэй хамтын ажиллагаанд тулгуурлан шат дараатайгаар хэрэгжүүлнэ

Нэг. Байгалийн хийн дэд бүтэц. Хийн хоолой болон дагалдах байгууламжийн судалгаа, зураг төсөл, зохицуулалт, бэлтгэл ажлыг хангана.

Хоёр. Тээвэр, логистикийн дэд бүтэц. Хийн хоолой болон дагалдах байгууламжийн судалгаа, зураг төсөл, зохицуулалт, бэлтгэл ажлыг хангана.

Гурав. Түлшний нийлүүлэлт. Зах зээлийн хэрэгцээ, бизнес загвар, нийлүүлэлтийн тогтвортой шийдэлд тулгуурлан ирээдүйн LNG, CNG боломжийг судална.